

12

ХҮҮХЭД ЗАЛУУСЫН ТӨЛӨВШЛИЙН АСУУДАЛ**Ц.Алтанчимэг****Хүүхдийн төлөвшлийн судлагдсан байдал**

Хүүхдийн хөгжлийг Монгол угсаатан бүрэлдэн тогтсон МЭӨ-I-III үеэс авч үзэж болох юм. Тухайлбал хүй нэгдлийн үед хүмүүс сүргээрээ амьдарч ан араатнаас биеэ хамгаалах үүдиээс чулуу мод шидэх, улмаар цаашид чулууmodoо хурцалж зэвсгийн чанартай бүтээгдэхүүн болон хэрэглэхийг зорьсон тэр үеэс бие биеэ ажиглан дууриах арга ухааны суурь тавигдсан гэж үзэж болно. Ингэж хүн хөгжсоноор эхийн эрхэт, эцгийн эрхт ёсноос эхлэн хүүхдийг хүмүүжүүлэх арга ухааны эх суурь тавигдаж тэдний төлөвшлийн асуудлыг судлах боломж бий болсон байна. Үүнийг тодорхойлох нэг жишээ бол хүүхдийг хүмүүжүүлж хөгжүүлж ирсэн монгол ардын сургааль, хүмүүжүүлэх өв уламжлал, зүйр цэцэн үг, үлгэр домог, сургаалын зохиолуудын утга агуулга юм. Үүнтэй уялдаж хүүхдийн төловшилийн судлагдсан байдлыг нилээд өргөн цар хүрээгээр хувьсгалаас өмнөх, хувьсгалаас хойшхи болон Ардчилал зах зээлийн гэж авч үзэхийг зорьсон болно

Хувьсгалаас өмнөх үеийн монгол ардын сурган хүмүүжүүлэх өв уламжлалын асуудал дотор хүүхдийг хүмүүжүүлж хөгжүүлэх арга ухааны асуудал дийлэнх байр суурийг эзэлдэг бөгөөд энэ үеийн хүүхдийн төловшил нь гэрийн хүмүүжүүлээр илэрхийлэгдэх бөгөөд манай ард түмний арвин баялаг өв уламжлал бүхий сургалт юм. Аль ч орны уламжлалт зан заншил нь ард түмний амьдралд бичигдээгүй хууль болон тогтсон байдал. Гэр бүлийн уламжлал гэдэг бол түүхэн хөгжлийн явцад өвөг дээдэс, эцэг эх, торол садан нийт олноороо дагаж эрхэмлэх болсон үеэс үед өвлөгдөн уламжлагдан баяжиж байдал

хүмүүжлийн үйл ажиллагаа болохыг доктор Т.Намжил өөрийн бүтээлдээ тодорхой гаргажээ²⁹.

“Монголчуудын гэр бүлийн харилцаанд тогтсон хүмүүжлийн хэм хэмжээ нь зүй тогтолц шинжтэй бүрэлдэж энэ нь амьдралдаа баримтлах зарчим болон уламжлагддаг байжээ. Монголчууд энэ зарчмыг баримталж дэгтэй, ахас ихэсээ хүндлэх сэтгэлтэй аливаад хүнлэг сэтгэлээр ханддаг ёс жудаг журамтай, сайн удам сайхан сургаалыт гэр бүлийг эрхэмлэдэг байжээ. Ийм гэр бүлд осож хүмүүжсэн хэн бүхэн баян ядуу, ноёд харц ялгаагүй ёс суртахуун дэг жаяг, хүмүүний ёсны хэмжээг даган сахиж түүнээс гаждаггүй байжээ. Энэ утгаараа хүүхдийн хүмүүжил төловшил нь тухайн нийгмийн онго аяст зохицсон нэлээд сайн сургалтаар олгогдож байжээ.” гэж үзсэн байна. Монголын ард түмний хүмүүжил төловшил олгох сургалтын бас иэг онцлог нь ахмад хүмүүс, багш, мэргэд нь хүүхдийг хүний оорийн, харц ноёны гэж ялгалгүйгээр сургадаг явдал юм. Түүнчлэн хүмүүжлийн орчин болон хүн бүрийн онцлогт тохирсон аргыг хэрэглэдэг байжээ. Эцэг эхгүй өнчин хүүхэд хүртэл хүүхдийн авах ёстой хүмүүжил төловшилийн сургаалийг сонсож сайхан сэтгэлийн өгөөжийг хүртэн хүмүүжиж байжээ. Энэ нь гэрийн, шашны, ардын аман зохиол гэх зэрэг аргаар олгогдох сургааль байлаа. Энэ бүхнийг харгалзан үзэж хувьсгалаас өмно үеийн монголчуудын уламжлалт хүмүүжлийн арга нь бүхэлдээ цогц шинжтэй тэр л үелээ хамаатай сайн хүмүүжил төловшил олгох шинжтэй байжээ гэж үзэж болно.

Бусад үндэстний нэгэн адилаар монгол хэмэх үндэстэн жинхэнэ монгол хүнийг сурган хүмүүжүүлдэг ухаантай мэргэд төрөн гарч, үеэс үед үзэл санаа нь хөгжин хөгжсөөр одгоо бидэнд овлогдож үлдсэн түүхтэй.

“Монголын ард түмэн хүнийг шинжихдээ түүний зан байдал, шинж чанар нь үнэн мөнөороо илрэн гарах хэлбэрийг олж тогтоон тодорхойлохын хамт түүний сөрөг талыг засаж залруулах аргыг зааж байсан нь сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх ухааны үндэслэлтэйн баталгаа болж байна”³⁰ гэж судлаач Г.Эрдэнэ-Очир өөрийн бүтээлдээ дурьдажээ. Мөн тэрээр “Монголчууд сурган хүмүүжүүлэх уламжлалынхаа хөгжлийн үр дүнд бие хүний тал бүрийн хөгжлийг олон талаас нь авч үзэн, бие хүн төловших үйл явцыг бүхэл бүтэн цогц болгон ойлгох болсон нь манай ардын сурган хүмүүжүүлэх зүйн нэг том ололт мөн” гэжээ.

Боловсрол эрдэм мэдлэг, хүмүүжлийн тухай үзэл санаанууд манай эртний болоод шинэ үеийн гарамгай сэтгэгчдийн зохиол бүтээлд оргөнөөр тусгагдаж ирсэн нь монголд боловсролын философиийг хөгжүүлэх баялаг хөрс болж байна. Тухайлбал их сэтгэгч Чойжил-Одсэр (XIV зуун), Лувсанпэрэнлэй Намхайжалцан (Зая бандита 1642-1715), Ч.Лувсанчүлтэм (1710-1810), Д.Ишбалжир (Сүмбо

²⁹ Г. Намжил “Монголчуудын гэр бүл” Тэргүүн давтэр УБ 1996

³⁰ Г. Эрдэнэ-Очир, “Монгол ардын сурган хүмүүжүүлэх уламжлал, түүний хөгжил”, Ph.D зэрэг горилсон бүтээс. УБ., 1993, x.93

хамбо 1704-1788), Д.Данзанравжаа (1803-1856), В.Инжинааш(1887-1891), Б.Тогтохтөр (1797-1850), Б.Данзанваанжил (1864-1907), Ж.Цэвээн (1880-1919) нарын эрдэмтэд өөрсдийн зохиол бүтээлдээ сурган хүмүүжүүлэх, төлөвшлийн мэргэн санаануудаа дэвшүүлж байлаа. Энэ үеийн гэр бүлд аж төрөх ёс, ёс суртахууны хүмүүжилд чухал нэмэр оруулсан хүн бол То ван юм.

Тэрээр “Тоть шувууны сургааль”-д “Ааль сайт охин”, “Шударга үнэнч хөвгүүн”, “Муу санаат хөвгүүн” гэж хүний зан төрх, ажил үйл, авир, араншин, монгол өвөг дээдсийн хүнийг үнэлэх үр хүүхдээ хүмүүжүүлэх, уламжлалт ухаанаар сурган заажээ. Тэрээр “Эдүгээ эцэг эх, ах нар, эгч бэргэдийг хүндэлхийг эс журам болговол хойно та нарыг хэн хүндэлж өргөнө”. “Олон иргэн бүгдээрээ хичээнгүйлэн ахчлах дүүчлэх ёслолыг хүндэтгэн хэрэглэгдэхүүнийг хэмнэж сайн иргэн болохын хичээ. Тэмцэл хэдрэх муу сургаалийг бүрнээ гээгтүн. Урьд манай өвгөд эмгэд авир бүдүүн мэт боловч аж төрөх, ахчлах, дүүчлэх ёслолд үнэхээр холч шударга тул баян талбиу явжээ. Тиймийн тухайд хуучны сургааль ёслолыг мөрдөн дагаж явбал сая буяныг бүтээнэ”³¹ гэсэн байдаг. 19-р зууны Монголын философи нийгэм улс төрийн сэтгэлгээний томоохон төлөөлөгч бол Дульдүйтэн Агваанлуvsанданзанравжаа юм.

Тэрээр нийгэмд оршиж буй гэм дутагдалыг засан сайжруулах арга замын тухай үзэл бодлоо дэвшүүлэн тавьж нийгмийн гай зовлонг анагаахын тулд хувь хүний ёс суртахууныг төгөлдөржүүлэх хэрэгтэй гэж үзжээ. Түүний алдарт “Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу” хэмээх зохиолд ёс суртахууны асуудлыг хөндөж тавьсан байдаг бөгөөд хувь хүний хүмүүжлийн бүр тодруулбал ёс зүйн нэлээд нарийн дэг журмыг зааж өгсөн байдаг. Ж нь :

Хэвцгээрхэж хөрүүл бүү үүсгэ
Хэгжүүрхэж омог бүү үүсгэ
Хордож бусдын гэмийг бүү малт
Ховлорч хэрэгтүй уг бүү зөө гэсэн байдаг.

Түүний ёс суртахууны сургаальд ёс зүйн ойлголтуудаар залуу үеийг хүмүүжүүлэх зорилгоор хүнлэг энэрэнгүй амьдралд идэвхтэй өөдрөг хандах үзлийг гаргасан байдаг.

“Сэтгэлийг амраагч оршивой” сургаальд бяцхан хөвгүүндээ зориулсан сургаальдаа “Биеийн цээрлэл, хэлний цээрлэл, сэтгэлийн цээрлэл, үзлийн цээрлэл, явдлын цээрлэл, нөхрийн цээрлэл, нутгийн цээрлэл, идээний цээрлэл, “зэргээр муу үйлсээс цээрлэж явахыг, сайн үйл эрхэмлэхийг” сэтгэлийн хичээл, амьдын хичээл, цагийн хичээл” хэмээн ангилан “Элдэв улстай нүүр учрах, хошуу холбох, гангалах явдлыг маш тэвч, худал бардам хоорөлхөх, хов, зусар уг, самуун явдлыг тэвч, хар, хор атаяа, тэнэг мунхаг омог тачаал, хармын сэтгэлийг зогсоо, ганц өөрийн бие хэлийг шүүмжил, олzonд хунгасах, өшигч хартай улсаас

³¹ “Их засаг”, УБ., 1995, x.31

хол яв, асар хурц махбодид хортой амтаар хуурах хоол хийгээд согтууруулах архи, бузар тамхи тэргүүтнийг тэвчигтүн”³² гэж сургасан байдаг.

Манай соёлын түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн В.Инжинаш шашин, шинжлэх ухаан хоёрыг зааглан ялгаж үндэснийхээ бичиг үсэгт сурч боловсон эх орны соёлын өвийг сайтар эзэмшин хүмүүний ёсонд үнэнч зөв төлөв хүмүүжилтэй иргэнийг бий болгон хүмүүжүүлэхийн чухлыг сургажээ. Энэ нь түүний “Хөх судар” романы Хонгорзулын дүрд энхийг эрхэмлэгч, хичээнгүй, нинжин сэтгэлтэй, эр чадалтай, хурц сэргээн оюун ухаантай, эрдэм номд мэргэн, монгол эмэгтэйн хэлбэрээр тусгагджээ³³.

19,20-р зууны зааг дахь Монголын нийгэм улс тор гүн ухааны сэтгэлгээний томоохон төлөөлөгч бол Чимэдийн Дандаа юм. Тэрээр өөрийн “Эрдэнэт толь” хэмээх шашдиртаа “Сургалт бол эцэг эхээс янаг, эзэн түшмэлдээ журамтай, эр эмийг тэгш үзэх, ах дуу элэгсэг, ахас эхэст зэрэг дэстэй, хань нохөр итгэмжтэй, өөрийн хүчээр аж тордөг архи дарс уух элдэв бус тоглоомоор наадахыг цээрлэдэг хүмүүжил өгсөн байх ёстой”³⁴ гэж боловсрол нь ёс суртахууны хүмүүжил олгож байж хүнийг төлөвшүүлэх зорилготой гэж бичжээ. Мон энэ үеийн Монголд гэгээрэл боловсролыг дээшилүүлэхэд идэвхтэй зүтгэж их хувь нэмэр оруулсан дэвшилтэг сэхээтэн бол Ж.Цэвээн юм. Тэрээр бүр 1911 онд “Гадаад олон хүчирхэг улсын хамаг чадал нь гагцхүү элдэв ухааны эрдэм дор нэвтрэлцэн зүйл бүрийн ухааныг өөр өөрийн төрөлх хэл дээр судалснаар хүчирхэг болжээ” гээд “Нийслэл хүрээний сонин бичигт”-т “Хүний оюун хэдийгээр мэргэн түргэн болоод олж мэдсэн нь цаглашгүй боловч ааш авир зан явдал нь сайнгүй ахул эрдэм сургасан хэрэг юун аж. Засгийг шинээр үүсгэн явуулахад улс төрд хэрэглэгдэх эрдмийн зүйлийг сургаваас сая зохино. Багш нар шавь сургагч нарынхаа авир зан ааш явдлыг сайнаар удирдаж аливаа авьяасыг нь сэргээн хөгжөөж нялх оюунд нь олон зүйлийн эрдэм зааж огөх эрхийг эдэлий” гэх зэргээр нийтлүүлж байлаа. Түүний Монголын боловсролыг хөгжүүлэх гол санаа нь:

- Нийгэм боловсрол 2 нягт холбоотой
- Боловсрол нь сургуулийн зорилт нь оюун ухааныг хөгжүүлж эрдэм ном заахаас гадна ёс суртахууны хүмүүжил олгож бис хүн төлөвшүүлэхэд чиглэнэ.
- Боловсролыг хөгжүүлэхэд гадаад орны туршлагыг авч хэрэглэхээс гадна өөрийн үндэсний онцлогийг тусгасан байх шаардлагатай : гэсэн байдаг.

Хувьсалаас хойш үеийн хүүхдийн хүмүүжил толовшил нь шинэ үеийн сургалтаар тодорхойлогдож болох юм. Энэ үед сургалт нь зөвхөн бие хүний өвөрмөц зан чанар, авьяас чадварыг хөгжүүлэх явдал биш харин нийгэмд зохицсон дуулгавартай иргэн төлөвшүүлэхэд чиглэж байжээ.

³² Д.Данланравжаа, “Үлэмжийн чанар”, УБ., 1991, х.185

³³ В.Инжинаш, “Хөх судар”, Тэргүүн дэвгэр

³⁴ Ч.Дандаа, “Эрдэнэт толь хэмэх шастир”, УНС

Тухайлбал: хүний зан үйлд сургалт, хүмүүжил, орчин хэрхэн нөлөөлж байсныг судалдаг бихевиорист чиг хандлагын үзэл ноёрхох болжээ.

Бихевиористуудын эсрэг үзлийг баримтлагч экзистенциалистуудын дэвшүүлсэн нийгмийн захиалгаас үл хамаарах боловсролын тогтолцооны тухай онол нь нийгмийг уналтанд хүргэсэн бөгөөд үүнийг шийдвэрлэхийн тулд нийгэм соёлын хөгжлийн чиг хандлага, шинжлэх ухаан техникийн хувьсал оорчлолтийн зорилт нь нийгмийн сонирхолд нийцсэн тийм боловсролын тогтолцоог бий болгох хэрэгтэй гэж шинэ бихевиористууд үздэг. Социализмийн үеийн гэж нэрлэж болох хувьсалаас хойш 90-ээд он хүртэлх үеийн боловсрол, гэр бүлийн уламжлалт хүмүүжил нь нийгмийн, хамт олны, нам, хувьсгалын үзэл бодлоор шинэчлэгдэн оорчлögдж бүхий л хүмүүжлийн нам нийгмийн үзэл бодлыг илэрхийлэхэд чиглэгдэх болсон байна. Ж нь:

Аль ч сургуульд хүмүүжлийн ажил нь бие хүний толовшилийн асуудлыг бүхэлд нь орхигдуулж

-Сүхбаатарын мэндэлсэн өдор

-Лениний төрсөн өдор

-Хувьсгалт намын өдор

-Гагарины мэндэлсэн өдор

-Октябрьн баярын өдор гэх мэт сэдвээр хийгдэх болжээ.

Энэ тухай судлаач С.Санжаабадам өөрийн бүтээлд дүгнэн бичихдээ “ЕБС-ийн сургалтын агуулга 1990-ээд он хүргэл освор үеийнхэнд тал бүрийн мэдлэг, ов тэгш хүмүүжил олгох онол, үзэл баримтлалыг үндэслэл болгон политехник боловсрол, коммунист хүмүүжил эзэмшилүүлэх чиглэлээр хөгжиж ирсэн юм. Өмнөх үеийн сургалтын агуулгад бүх хүүхдийг ижил агуулга, аргаар ижил түвшинд сургах зорилт тавьсан нь нэг талаар алдаатай бодлого байжээ”³⁵ гэжээ. Шашингүйн үзлийг сурталчлан нийгэм тэр аяараа хамтын коммунист нийгмийг бүтээн байгуулахаар зорьж, хувь хүний амьдрал, толовшил, хүмүүжлийн асуудал боловсролын бодлогын гадна үлдэж байлаа. Ингэснээр угаас амьдралын орчноос танхимиын бус замаар олох боловсрол үгүй болж энэ тухай сургалтын арга, технологи, агуулга гэж боловсруулж байгаагүйгээс өнөөдор чухлаар тавигдаж байгаа тасралтгүй боловсролын агуулга гэж байхгүй болжээ. Энэ утгаараа танхимд өгч байгаа мэдлэгийг боловсрол хэмээн тооцож диплом овортолсон бол боловсролтой иргэн гэж тооцон хүүхдийн хүмүүжил толовшилийн асуудлыг тэр чигээр нь орхигдуулжээ. Яг энэ үеэс боловсролын хямрал эхэлж хүнийг цогцоор нь хүмүүжүүлэх боловсролын зорилго алдагдсан байна. Хэдий тийм ч угаас уламжлалт гэр бүлийн хүмүүжилтэй хөрсөнд боловсорсон шинэ үеийн сэхээтэн, ажилчин, малчин, хөдөлмөрчин гэр бүл тогтвортой байж өөр өөрийн үе дамжин ирсэн сургалтын аргыг хэрэглэн үр хүүхдэдээ танхимиийн гадуур сургалтаар хүн ёс, толовшилийн сургалтыг явуулсаар байлаа. Монгол ардын аман зохиол судлах, угсаатны зүйн судалгаа, шинжилгээний зарим бүтээл туурьвилд манай ардын

³⁵ С.Санжаабадам, “Боловсролын чанар ба Монгол хүний хөгжлийн хамаарал”, Ph.D зэрэг горилсон бүтээл, УБ., 2001, х.21

сурган хүмүүжүүлэх зүйн асуудлыг 60 , 70-аад онд хөндөж хэвлэлийн хуудаснаа тусгах болжээ. Тухайлбал :


Гүн ухааны эрдэмтэн Д.Дашкамц, Ц.Дамдинсүрэн, Б.Ширэндэв, Ж.Лувсандорж, Чой.Лувсанжав, П.Хорлоо, С.Баясгалан, угсаатны зүйч Х.Нямбуу, С.Бадамхатан нарын зэрэг хүмүүс сонирхолтой өгүүлэл товхимол бичиж эхэлсэн бөгөөд үүгээр Ш.Гаадамба, Л.Түдэв, Д.Дашкамц, Х.Нямбуу, Х.Сампилдэндэв, Х.Дарамбазар, С.Шадартовуу, Х.Ховд-Абай зэрэг манай эрдэмтэд шинжилгээ судалгааны бүтээлээ түүрвих болжээ. Гэвч энэ үеийн монгол хүүхдэд хүмүүжил, төлөвшил олгох сургалт нь дан ганц айл өрх бүлийн шинжтэй байсан ба энэ талаар бодлого байхгүй байсан учир хүүхдийн хүмүүжил төлөвшлийн асуудал нь дан ганц тэр хүүхдийн өсөн торниж байгаа орчноос шалтгаалан ялгавартай байдлаар хөгжих болжээ. Энэ нь нөгөө талаас нь авч үзвэл гэр бүл хүмүүжлийн орчин нь л нийгмийн хувьслаар өөрчлөгдхөх тохиолдолд л улс орны ирээдүйг авч явах хүүхдийн хүмүүжил төлөвшил ч бас түүнийг даган өөрчлөгдхөх ёстой байдалд хүрсэн гэж үзэж болно.

Арчилал зах зээлийн үеийн Монголын хүүхдийн төлөвшлийн байдал нь 1990 оноос Монголд арчилалын хөдөлгөөн өрнөж Монгол улс хувьсгалт нийгмийн үзлэс ангижран чөлөөт зах зээлийн нийгэмд шилжсэнтэй холбоотой юм. Хүнд байгалиас заясан аливаа зан чанар, авьяас чадвар нь зөвхөн нийгэмшүүлэх явцад илэрч, нийгмийн орчноос түүний цаашдын өсөлт хөгжилт шалтгаална. Чухам энэ л шинжийг илэрхийлэн боловсролын pragmatizmийн урсгалын анхаарах болжээ. Энэ нь “бие хүн нийгмийн харилцааны зохистой байдлыг хангахын тулд боловсролын тогтолцоог боловсронгуй болгож байх хэрэгтэй. Учир нь нийгэм эдийн засгийн тогтолцоонд гарч байгаа, олон улсын байдал зэргээс социал харилцаанд нийцсэн нийгмийн захиалгат хүний төлөвшүүлэхийн тулд боловсролыг зайлшгүй өөрчлөх хэрэгтэй болдог. Хэрэв үүнийг хийхгүй бол боловсрол нийгмийн хэрэгцээг хангахаа больж хямарч эхэлнэ. Иймээс боловсрол нь хүн орчиндоо зохицож, нийгмийн дотор амьдрах аргыг сургах зорилготой юм” гэж pragmatistууд үздэг. Зах зээлийн нийгэмд шилжих үеийн хямрал нь хүмүүжил төлөвшилийг олгох байсан цорын ганц зүйл болох гэр бүл хүүхдийн өсөн торниж, төлөвшиж байсан орчинд нь нөлөөлөх болжээ. Зах зээлийн амьдралын төлөөх ширүүн тэмцэлд өмч хөрөнгөгүй ядуучууд олноор бий болж хүүхэд хүмүүжүүлэх, тэжээх чадваргүй гэр бүл олширч тэнэмэл хүүхдүүд гэх цоо шинэ ойлголт бий боллоо. Дөнгөн өл залгах өрхүүд хүүхдийн хүмүүжлийг бас л орхигдууллаа. Ажилгүйдэл, архидалт ихсэж, гэр бүл салалт, өрх гэр толгойлсон эмэгтэйчүүд олширсон нь хүүхдийн хүмүүжил төлөвшилд нөлөөлөх болжээ. Амьдралаа дээшлүүлэх зорилгоор гадаадад ажиллах нь олширч 20 хүүхэд тутмын нэгнийх нь эцэг эхийн аль нэг нь эсвэл хоёулаа гадаадад ажиллах болсноор хиймлээр эцэг эхгүй өсөх ончин хүүхдүүд нэмэгджээ. Ийм гэр бүлийн нэлээд нь салж байгааг харгалzan үзэх ёстой. Сүүлийн жилүүдэд гэр бүл салалт маш их хурданаар өсжээ. Энэ бүх шалтгааны улмаас гэр бүл, хүүхэд өсөн торних орчны хүмүүжил төлөвшлийн

сургалт нь алдагдаж Монгол хүүхдийн хүмүүжил төлөвшлийн сургалт бүхэлдээ байхгүй болсон гэж үзэж болно.

Судлаач С. Эрдэнэцэцэг өөрийн бүтээлдээ доорхи бүдүүвчийг дүрсэлжээ³⁶.

Өнөөгийн олгох буй боловсрол



Дэвшүүгж буй боловсролын шинэ бүтэц



Дээрх бүдүүвчийг авч үзвэл пирамидыг эргүүлж зөв сууринд нь тавих нь тогтвортой зөв боловсролын тэнцвэрийг хангаж болохыг ойлгож болно. Хэрэв бил хүний зөвхөн оюун ухааныг бус зүрх сэтгэлийг бүхэлд нь төлөвшүүлэхэд сургалтаа чиглүүлж чадвал бат тогтвортой боловсролыг төлөвшүүлэх, хүний хөгжлийн эрхэм зорилгыг биелүүлэх боломжтой юм. Хүмүүжлийн хэмжээ түүнтэй холбогдох боловсролын концепцыг тодруулах шаардлагатай. Энэ талын зарим сургалтыг сургалтын олон хэлбэрээр явуулах болсон. Жишээ нь :

Харьцааны сөбл, биеэ зөв авч явах, дайллага цайллагад оролцох ёс горим, зөв будах аргачлал, гуалиг болох дасгал, хоол хийх урлаг, хувцасаа тохируулах чадвар гэх мэт танхимиин бус мэдлэг олгох, нийгмийн амьдралын мэдлэгийг олгох сургалтууд байна. Аль ч сургуулийн ерөнхий боловсролын сургуулийн хүмүүжлийн ажил нь ямар нэгэн ойн баярын үйл ажиллагаанууд, концерт, цуглаан, тэмцээн эсвэл ангийн багшийн зүгээс хийх, сургуулийн захиргаа бусад байгууллагын мэдээ тооцоо, шаардлагыг дамжуулах яриа маягаар явж ирсэн нь хүн бүрт тодорхой билээ.

ДҮГНЭЛТ

Танхимиин сургалтаар олгох хүмүүжлийн ажил агуулгын хувьд өөрчлөгдж гэр бүл төлөвлөлт, сурагчдын хууль эрх зүйн мэдлэг, тэдний эдлэх эрх үүргийн тухай, арьс өнгөний өвчин, ДОХ-той тэмцэх өдөр бэлгэвч хэрэглэх гэх мэт яриа лекц явуулж уралдаан тэмцээн зохиох болжээ. Мэдээж бүгд хамгийн халуун цэгийн ярианууд. Гэхдээ хүмүүнлэгийн хүн чанарын тухай сайхан жишээн дээр тулгуурласан сэтгэл хөдөлгож, нулимс ялгах хүнч сэтгэлийг хөндсөн гэгээлэг яриа лекц бас л орхигдож сайн хүн болгох сургалт дутагдсаар л байна. Элдэв

³⁶ С.Эрдэнэцэцэг, ““Гэр бүлийн ёс зүй” хөтөлбөрийг хувьсах агуулгаар судлуулж хүүхдийн ёс суртахууны хөгжлийн түвшинг дээшлүүлэх нь”, Ph.D зэрэг горилсон бүтээл, УБ., 2002, х.24

муу санаа муухай зуршилд автаж амжаагүй хүүхдүүдэд минь сайхан муухай, хэрэгтэй хэрэггүй, зайлшгүй шаардлагагүй гэх мэт зүйлсийн ойлголтыг өгч чадахгүй байгаа нь сэтгэл зовоох асуудал болоод байна. Хүч түрэн орж ирж байгаа мэдээллийн янз бүрийн сувгаар хүүхдүүд маань аллага хядлага хүчин, тамалт, дээрэм, тонуул, архидалт, завхайрал гэх мэт нийгмийн хамаг муу муухайг багш бид нараас өрсөлдөн сурталчилж байна. Чухам ийм учир сурган хүмүүжүүлэгч эрдэмтэн судлаач билээ залуу үеэ барьж хүний ёсны сайхан зан чанар хүмүүжлийг олгож ирээдүйн төлөвшөөн ухаалаг хүмүүнлэг аав ээжийг бэлтгэх том зорилтыг тавин шуурхай ажиллах шаардлагатай болжээ. Үүний тулд хүн төлөвшиход нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг нэгдсэн цогц байдалд нь авч судлах шаардлага гарч байна.

Ашигласан ном зүй.

1. Т. Намжил “Монголчуудын гэр бүл” Тэргүүн дэвтэр .УБ 1996
2. Г.Эрдэнэ-Очир, “Монгол ардын сурган хүмүүжүүлэх уламжлал, түүний хөгжил”, Ph.D зэрэг горилсон бүтээл, Уб., 1993, x.93.
3. Д.Данзанравжаа, “Үлэмжийн чанар”, УБ., 1991, x.18
4. В.Инжаннаш, “Хөх судар”, Тэргүүн дэвтэр
5. Ч.Дандаа, “Эрдэнэт толь хэмээх шастир”, УНС
6. С.Санжаабадам Ph.D зэрэг горилсон бүтээл, “Боловсролын чанар ба Монгол хүний хөгжлийн хамаарал”, УБ, 2001, 21x
7. С.Эрдэнэцэцэг, Ph.D зэрэг горилсон бүтээл “Гэр бүлийн ёс зүй” хөтөлбөрийг хувьсах агуулгаар судлуулж хүүхдийн ёс суртахууны хөгжлийн түвшинг дээшлүүлэх нь”, УБ, 2002, 24x